



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/400

Зуунмод

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
шилжүүлсэн хугацааг сунгаж, авч хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “б”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоолын 1, 3, мөн 2021 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, 2021 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын 1, 2021 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Түр журам батлах тухай” тушаалын 2, 4, “Хот болон орон нутаг хооронд иргээдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын 1.1, 2, 3, 6, 7, Улсын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр “Халдварт хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” албан даалгаврын 4, 5, 6, 9, мөн 2021 оны 21 дүгээр Хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2.1. Аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацаанд төрийн байгууллага, хуулийн этгээд, хүний үйл ажиллагааны зохицуулалтыг батлагдсан журамд заасны дагуу зохион байгуулж, халдварт тархахаас урьдчилан сэргийлэх, халдварт тархалт нэмэгдсэн тохиолдолд тэмцэх хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), аймгийн Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар), сумын Засаг дарга нарт даалгасугай.

2.2. “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтийг орон нутагт бүрэн ханггуулж, үйл ажиллагааг нь

нээсэн худалдаа, үйлчилгээний салбаруудын цагийн хуваарь болон зарим бараа бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээнд зохицуулалт хийж, халдвартархад эрдэлээс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч, хатуухяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.3. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакцинуулалтын ажлыг аймгийн хэмжээнд эрчимжүүлж, вакцинуулалтад иргэдийг бүрэн хамруулах, бүх нийтийн дархлааг дэмжих ажлыг үе шаттай хэрэгжүүлж, 12-17 насын хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийг вакцинуулах ажлыг аюулгүй, өргөн хүрээнд бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулж, вакцинд хамруулах шинжилгээний цэг, цэгүүдийн байршилыг тодорхой болгож, эцэг эхчүүдийг хүүхдээ вакцинд эрчимтэй хамруулах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр зөвлөмж, мэдээлэл тогтмол хүргэж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллах,

-Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг илүү сайжруулах, эмнэлзүйн багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

-Гэрээр тусгаарлагдан эмчлэгдэж байгаа коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж орон нутгийн төсвийн нөөц боломжид тулгаруулан үе шаттай шуурхай шийдвэрлэх, эм, эмийн хэрэгслийн хангалтыг тасралтгүй нийлүүлж, хэрэглээнд хяналт тавих,

-Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолыг тусгаарлан эмчлэх байр, эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх цэгийг боломжит байршилд нээж ажиллуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

-Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт, эрэмбэлэн ангилалт, шаардлагатай эмчилгээний талаарх зөвлөмж зөвлөгөө, мэдээ, мэдээллийг боломжит бүх сувгаар иргэд, олон нийтэд тогтмол хүргэх,

-Эмч, эмнэлгийн ажилтны хүний нөөцийн хэвийн үйл ажиллагааг хангах, хангалтыг нэмэгдүүлэх, гамшгийн уед дайчлагдан нэмэлтээр ажиллах байгууллага, төрийн албан хаагчдын судалгааг гаргаж, энэ талаар холбогдох зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллах,

-Эрчимт эмчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй 24 цагийн үйл ажиллагаатай шуурхай багийг байгуулж, хүндрэл, нас барагтаас сэргийлэх бүхий л нөөц боломжийг дайчлан ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2.4. Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын халдвартгүйжүүлэлтийн ажилд хяналт тавьж, бүртгэлийн цахим системийн QR код байршуулаагүй, үйлчлүүлсэн иргэдийг бүртгээгүй, халдварт хамгааллын дэглэм, холбогдох дүрэм журам мөрдөөгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсох хүртэл арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т чиглэл болгосугай.

2.5. Орон нутгийн орох, гарах чиглэлд байнгын ажиллагаатай хяналтын цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шаардлагатай тохиолдолд хяналтын түр цэгийг байгуулах, “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын хэрэгжилтийг хангаж, албан хаагчдыг хүч нэмэгдүүлэн ажиллуулж,

маршрутын бус замаар зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд төрийн бусад байгууллагын албан хаагчдыг дайчлан ажиллуулж халдвартархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

-Хот хооронд болон орон нутагт зорчих иргэдийн хөдөлгөөнийг тухайн сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр хөдөлгөөн үйлдүүлэхийг сумын Засаг дарга нарт чиглэл болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга бөгөөд Онцгой комиссын орлогч (Н.Төмөрбаатар), Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг) нарт даалгасугай.

2.6.Аймгийн хэмжээнд коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр олон нийтэд мэдээлж, сэрэмжлүүлж, мэдээлэл хүргэх ажлыг боловсронгуй болгон хүртээмжийг нэмэгдуулж ажиллахыг аймгийн Нэгдсэн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (С.Цогбаяр)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/346 дугаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгаж, авах зарим арга хэмжээний тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР

